

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ
БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 1999 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр баталсан Иргэний нисэхийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2019 оны ... дугаар сарын ... -ны өдөр баталсан Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтыг дор дурьдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 1 дэх заалт:

1. Утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татсан, эсхүл татах боломж олгосон бол хүнийг **таван зуугаас мянган нэгжтэй** тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2/ 14 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийн 1 дэх заалт:

1. Иргэний нисэхийн дүрэмд заасан баримт бичгийн бүрдэлгүй, эсхүл зохих зөвшөөрөлгүйгээр нисэхийн үйл ажиллагаа эрхэлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, хүнийг **хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр**, хуулийн этгээдийг **хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр** торгоно.

3/ 14 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийн 2 дахь заалт:

2. Хуулиар эрх олгогдсон этгээд нисэхийн аюулгүй байдлын үзлэг шалгалтыг зохих журмын дагуу хийгээгүй бол үзлэг шалгалт хийх эрхийг нэг жил хүртэл хугацаагаар хасаж, нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4/ 14 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийн 3 дахь заалт:

3. Иргэний нисэхийн үйл ажиллагаанд нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам зөрчсөн бол нисэхийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг нэг жил **хүртэл** хугацаагаар хасаж хүнийг **таван зуугаас мянган нэгжтэй** тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг **таван мянгаас арван мянган** нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5/ 14 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийн 4 дэх заалт:

4. Нислэгийг хэвээр үргэлжлүүлэх боломжгүй онцгой тохиолдлын талаар хүндэтгэх шалтгаангүйгээр мэдээлээгүй агаарын хөлгийн даргыг **таван мянган** нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6/ 14 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийн 5 дахь заалт:

5. Иргэний нисэхийн хамгаалагдсан бүсэд хууль бусаар нэвтэрсэн хүнийг **нэг зуугаас нэг зуун тавин** нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7/ 14 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн 1 дэх заалт:

1. Агаарын зайг нисэхэд ашиглах журам зөрчсөн бол агаарын хөлгийн даргыг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8/ 14 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн 3 дахь заалт:

3. Агаарын зайн зөрчил үйлдсэн агаарын хөлгийн даргыг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2 дугаар зүйл. Зөрчлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн **2** дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2019 оны ... дугаар сарын ... -ны өдөр баталсан Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.24 дэх заалтын “нислэгийн аюулгүй ажиллагааны” гэснийг “нисэхийн аюулгүйн хяналтын” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2019 оны ... дугаар сарын ... -ны өдөр баталсан Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**УЛСЫН НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Улсын нисэхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “Иргэний нисэхийн тухай хуулийн 3 дугаар зүйлд” гэснийг “Иргэний нисэхийн тухай хуулийн 5 дугаар зүйлд” гэж, 6 дугаар зүйлийн 6.2.3 дахь заалтын “агаарын хаалгаас” гэснийг “орох, гарах цэгээс” гэж, 9 дүгээр зүйлийн 9.3.1 дэх заалтын “Иргэний нисэхийн тухай хуулийн 18.2-т” гэснийг “Иргэний нисэхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Улсын нисэхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл Энэ хуулийг 2019 оны ... дугаар сарын ... -ны өдөр баталсан Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлд дараах агуулга бүхий 16.1.15 болон 16.1.16 дахь заалт нэмсүгэй:

1/ “16.1.15 олон улсын болон орон нутгийн нислэгт ашиглах аэродром, аэродром орчмын аюулгүйн бүсийн газар”

2/ 16.1.16 ерөнхий зориулалтын нисэхт ашиглах зурвас, талбай”

2 дугаар зүйл. Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “16.1.11,” гэсний дараа “16.1.15” болон “16.1.16” гэж, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын “16.1.14” гэсний дараа “16.1.16” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2019 оны ... дугаар сарын ... -ны өдөр баталсан Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дараах агуулга бүхий 13 болон 14 дэх заалт нэмсүгэй:

“13/ олон улсын болон орон нутгийн нислэгт ашиглах аэродром, аэродром орчмын аюулгүй бүсийн газрын”

14/ ерөнхий зориулалтын нисэхт ашиглах зурвас, талбайн”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2019 оны ... дугаар сарын ... -ны өдөр баталсан Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**АГААРЫН ЗАЙГ НИСЭХЭД АШИГЛАХ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “Иргэний нисэхийн тухай хуулийн 3 дугаар зүйлд” гэснийг “Иргэний нисэхийн тухай хуулийн 5 дугаар зүйлд” гэж, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, мөн зүйлийн 6.4 дэх хэсгийн “агаарын хаалгыг” гэснийг “орох, гарах цэгийг” гэж, мөн хэсгийн “Иргэний нисэхийн тухай хуулийн 7.1.3-т” гэснийг “Иргэний нисэхийн тухай хуулийн 8.1.16-д” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтын “агаарын хаалгаар” гэснийг “хилээр орох, гарах цэгээр” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2019 оны ... дугаар сарын ... -ны өдөр баталсан Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.8. дахь заалтын “нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгоход” гэсний өмнө “Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөгт” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн 29 дүгээр зүйлийн 29.1.8 дахь заалтын “16 000 - 40 000” гэснийг “2 000 000 – 5 000 000” гэж, 12 дугаар зүйлийн 12.4.1 дэх заалтын “17 600 - 44 000” гэснийг “500 000 – 1 000 000” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1.7 дахь заалтын “агаарын хөлгөөр нислэгийн” гэснийг “агаарын тээврийн” гэж, мөн заалтын “60 000 - 150 000” гэснийг “3 000 000 - 5 000 000” гэж, мөн зүйлийн 29.1.11 дэх заалтын “18 000 - 44 000” гэснийг “1 500 000 – 2 000 000” гэж, 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийн “12 000-30 000” гэснийг “250 000 – 500 000” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгээс “агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ” гэснийг, мөн зүйлийн 12.4.4 дэх заалтаас “ашиглалтаас хасах, тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулаагүй гадаадын байгууллагад болон Монгол Улсын харьяат бус бөгөөд тус улсад оршин суудаггүй хүнд худалдсан, шилжүүлсэн тохиолдолд” гэснийг тус тус хассугай.

4 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4.2, 12.4.3 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг 2019 оны ... дугаар сарын ... -ны өдөр баталсан Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ